



### ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖЛУУД:

20 албан хаагчтай байнгын ажиллагаатай “Эрэн хайх аврах бүлэг” байгуулахаар улсын төсөвт 1.8 тэр бум төгрөг суулгасан. Сумын ерөнхий хөгжлийн төлөвлөгөөний дагуу шинээр хашааны газар олгох, зам засварлах, гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, 0.4 шугамын өргөтгөл засвар хийх, 2024 онд болох сумын 100 жилийн ойг угтан бүтээн байгуулалтын олон ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

### СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах албан хаагчдыг орон байр бусад нөхцөлөөр хангах, эрчимжсэн мал аж ахуй, жижиг дунд үйлдвэр эрхлэх иргэдэд сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олгох шилжин ирж буй иргэдэд шинээр хашааны газар олгох боломжтой.

Сэлэнгэ аймаг Цагааннуур суманд суурьшихаар ирж буй хүмүүс “цэвэр, бохир, дулаанд холбогдсон авто машины дулаан гарааш” бүхий Хаус хороололд сууц аван амьдрах бүрэн боломжтой.



ЦАГААННУУР СУМ



# НЭЭЛТЭЙ СЭЛЭНГЭ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ:

1976 онд атрын 2-р аяны хүрээнд БНМАУ-ын СНЗ-ийн 376 тоот тогтоолоор Түшиг сумын Зэлтэрийн САА-н Цагааннуурын 2 дугаар тасгийг түшиглэн үр тариа, нарийн ноост хонь, саалийн механикжсан ферм гэсэн аж ахуйн чиглэлтэйгээр, “Найрамдал” САА буюу одоогийн Цагааннуур сум шинэчлэн байгуулагдсан түүхтэй.



99823788



<http://tsagaannuur.se.gov.mn>

Цагааннуур сум нь аймгийнхаа баруун хойд хэсэгт оршдог. 381,4 мянган га нутаг дэвсгэртэй. Улаанбаатар хотоос 400 км, аймгийн төвөөс 90 км, төмөр замын зангилаанаас 76 км зайнд оршдог. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг. Нутгийн ихэнх хэсэг хүрэн хүрээтэр хөрстэй. Газар тариалан, мал аж ахуй хосолсон МУ-ын газар тариалангийн томоохон сумуудын нэг юм.

Цагааннуур сум нь 3 багтай, 1363 өрх, 5088 хүн амтай, төсвийн болон хувийн хэвшлийн 133 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг, ИТХ, ЗДТГ, ЕБС, Эрүүл мэндийн төв, 1, 2 дугаар цэцэрлэг, соёлын төв, спорт цогцолбор, сум дундын ойн анги “Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ зэрэг төсвийн байгууллагууд төрийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Сумын хэмжээнд газар тариалан, мал аж ахуй, аж үйлдвэрийн салбарын хэмжээнд жилд 30,0-50,0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд борлуулдаг.

## СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ, ЯМАР ЧИГЛЭЛЭЭР ХӨГЖИХ БОЛОМЖ:

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум нь 2016 онд Монгол улсын Тэргүүний сумаар шалгарсан бөгөөд Сэлэнгэ аймгийн Цагааннуур Зүүнбүрэн, Түшиг сумыг хамарсан Сэлэнгэ бүсийн төв сум юм.

Сумын төв нь дулаан, цэвэр, бохирын нэгдсэн шугамд холбогдсон төр төсвийн байгууллагууд, томоохон аж ауйн нэгжүүд, төвийн зарим айл өрхүүд нэгдсэн шугамд холбогдсон. Цаашид байгууллага, айл өрхүүд нэгдсэн шугамд холбогдох боломжтой.

Улсын төсвийн хөрөнгөөр 15 ортой эрүүл мэндийн төвийн өргөтгөл баригдан 2023 оны 11 дүгээр сард ашиглалтад орох бөгөөд сум дундын эрүүл мэндийн төв болох зорилт тавин ажиллаж, 2023 оны 10 дугаар сард шүдний кабинет ашиглалтад оруулж мэргэжлийн их эмчээр хангагдан ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга баригдаж байна.

Цагааннуур сум нь Монгол улсын газар тариалангийн томоохон сумдын нэг бөгөөд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад байгаль цаг уурын нөхцөл бүрдсэн. Улаанбаатар хот, Дархан хот, Эрдэнэт хотруу хатуу хучилттай авто замаар холбогдсон. Цаашид Түшиг сумын Бооцын хил нээгдсэн тохиолдолд ОХУ-тай худалдаа наймаа хийх, транзит тээвэр хийх нөхцөл боломж бүрдэнэ.

Жижиг дунд үйлдвэрлэл, төмс хүнсний ногоо тариалах, загас, ан агнуур, аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.



Улс, Аймаг, сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд 2021-2023

2021-2023 онд улсын болон аймаг сумын хөрөнгө оруулалтаар 8,9 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:

Хатуу хучилттай зам, Сургуулийн өргөтгөл, Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Эрүүл мэндийн төвийн бохирын хоолойг шинэчлэх ажил, Бохирын машинтай боллоо, Спорт цогцолборын засварын ажил, Мэдээлэл зүйн кабинет, Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, Баяр наадмын талбайн засвар, Хатуу хучилттай автозамын үргэлжлэл, Ебс-ийн агааржуулалтын хоолой, Гэр чулууны давааны засварын ажил, Сити нойл, хогийн цэгийн хашаажуулалт, Камержуулалт, Ногоон байгууламжийн тохижилт, 3 дугаар багт цэвэр усны шугам татсан, Гудамж талбайн камержуулалт, Явган хүний зам, Гэрэлтүүлэг, 2,3 дугаар багийн шороон зам засалт, Хог түрдэг техник, Хорооллын тоглоомын талбайн тоглоом шинэчлэх хашаажуулах, 1 дүгээр цэцэрлэгийн бохирын засвар, 2 дугаар цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, Цагааннуур тохижилт ААТҮГ-ын тоног төхөөрөмж, Ногоон байгууламжийн торон хашаа, Хүүхэд хамгаалалын өрөө зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.